



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 513

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлж, үнэ шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төв аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 62,550,000.00 /жаран хоёр сая таван зуун тавин мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий, автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 2,000,000.00 /хоёр сая/ төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож, Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга Ц.Ганболд, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал А.Батчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашины улсын бүртгэлийг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
51.3... дугаар тогтоолын хавсралт



Төв аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн
төвд балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)
1	Ландкрузер-100, 09-57 ТӨВ, арал№ JTECJ09J105512208	2006/ 2007	62,550,000.00	1	2,000,000.00
	Нийт дүн		62,550,000.00/жар ан хоёр сая таван зуун тавин мянган/	0	2,000,000.00 /хоёр сая төгрөг/